



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 32

Сүхбаатар

Комисс томилох тухай

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 5-ын 19 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Биеийн тамир спортын газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Гишүүд:

Д.Ёндонжамц

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн

Д.Лувсандагва

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

Б.Ариундэлгэр

-Хүний нөөцийн мэргэжилтэн, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2.Сонгон шаггаруулалтыг зарласан хугацаанд зохих журмын дагуу зохион байгуулан дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Ариундэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА